

ОЛОН ХОТ БА БҮСИЙН ТЭМЦЭЭН

“БУЛГАН ЦОМ-2019” ОЛИМПИЙН ТАЕКВОНДОГИЙН ОЛОН ХОТЫН НЭЭЛТТЭЙ ТЭМЦЭЭН

“Булганы цом-2019” олимпийн таеквондогийн олон хотын аварга шалгаруулах 13 дахь удаагийн нээлттэй тэмцээн 2019 оны 01 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн 22 клубын 250 гаруй тамирчид оролцлоо. Багийн дүнгээр: Өсвөр насны ангилалд I байр Орхон аймаг, II байр “онхе” клуб, III байрыг Зүүнхараа багийн тамирчид мөн Бага насны ангилалд: I байр Орхон аймаг, II байр “Нэгэн бүл” клуб, III байр “Эхлэл” клубын баг тамирчид эзэллээ. Шилдэг шүүгчээр Булган аймгийн шүүгч Б.Баянмөнх, Шилдэг



дасгалжуулагчаар Орхон аймгийн дасгалжуулагч Б.Хос-хүлэг, Шилдэг эмэгтэй тамирчнаар “Хүч” спорт хорооны тамирчин Г.Отгончимэг, Шилдэг эрэгтэй тамирчнаар “Конхе” клубын тамирчин Ё.Пүрэвдаш нар тус тус шалгарлаа.

“ ТӨВИЙН БҮСИЙН ЖҮДО БӨХИЙН ТЭМЦЭЭН “

Төвийн бүсийн Жүдо бөхийн Өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 03 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд спорт ордонд зохион байгуулагдаж, тус тэмцээнд Орхон, Төв, Сэлэнгэ, Дархан уул, Булган аймгуудын 381 тамирчид 47 жингээр оролцлоо.



“БУЛГАН АЙМГИЙН ПАУЭРЛИФТИНГИЙН ХОЛБООНЫ “АНХДУГААР НЭЭЛТТЭЙ ТЭМЦЭЭН”

Булган аймгийн Пауэрлифтингийн Холбооны “Анхдугаар нээлттэй тэмцээн” 2019 оны 12 дугаар сарын 13-14-ны өдрүүдэд Булган суманд амжилттай зохион байгуулагдаж нийт 9 баг, клубын Булган, Орхон, Хөвсгөл, Сэлэнгэ, Улаанбаатар хотын “Манлай хүчтэн”, “Стронг”, Power house, “Мустанг” Хархорум” клубүүд, давхардсан тоогоор 130 гаруй тамирчид оролцлоо. Тэмцээний багийн дүнгээр Булган аймаг Тэргүүн байр, Орхон аймаг Дэд байр, Улаанбаатар хотын “Манлай хүчтэн” клуб Гутгаар байранд тус тус шалгарлаа.



ҮНДЭСНИЙ БӨХИЙН БАРИЛДААН

Монгол улсын даян аварга С.Цэрэнгийн мэндэлсний 80 жилийн ойд зориулсан өсвөр үеийн бөхийн барилдааыг 14-15, 16-17 насны ангилалаар 2019 оны 11 дүгээр сарын 07-08-ны өдрүүдэд тойргийн журмаар явууллаа. Барилдаанд Баян-Өлгий, Архангай, Өвөрхангай, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Булган аймгийн 20 гаруй багийн 80 гаруй өсвөрийн бөхчүүд оролцож, багийн дүнгээр I байранд Аймгийн арслан Б.Сүхбаатар дасгалжуулагчтай Дархан-Уул аймгийн баг тамирчид, II байранд Т.Золбадрах дасгалжуулагчтай Хишиг-Өндөр сумын баг тамирчид, III байранд Д.Мөнхсүлд дасгалжуулагчтай Өвөрхангай аймгийн баг тамирчид тус тус шалгарлаа.

